

**ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ
БАЙГУУЛЛАГУУДЫН 2020 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН**

Огноо:2020.04.25

Нэг. Ерөнхий мэдээлэл

Аудитын код:	САГ-2021/14/СТА-ТЕЗ	Шалгагдсан байгууллага, нэгжийн нэр:	Үндэсний статистикийн хороо
Аудит хийсэн бүтцийн нэгжийн нэр:	Аудитын хоёрдугаар газар	Аудит хийсэн баг, албан тушаалтан	Аудитор Ж.Нямцэцэг

Хоёр. Байгууллага, нэгжийн тоо болон санал дүгнэлтийн талаарх мэдээлэл

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр/ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Гаргасан санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудит хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр				Зөрчилгүй	Хязгаарлалтай	Сөрөг
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт	Итгэл үзүүлсэн	Аудит хийгээгүй			
A	1	2	3	4	5	6	7	8	9
1	Үндэсний статистикийн хорооны дарга	1	1				1		
2	Архангай аймаг дахь Статистикийн хэлтэс	1	1				1		
3	Баян-Өлгий аймаг дахь Статистикийн хэлтэс	1	1				1		
4	Баянхонгор аймаг дахь Статистикийн хэлтэс	1	1				1		
5	Булган аймаг дахь Статистикийн хэлтэс	1	1				1		
6	Говь-Алтай аймаг дахь Статистикийн хэлтэс	1	1				1		
7	Говьсүмбэр аймаг дахь Статистикийн хэлтэс	1	1				1		
8	Дархан-Уул аймаг дахь Статистикийн хэлтэс	1	1				1		
9	Дорноговь аймаг дахь Статистикийн хэлтэс	1	1				1		
10	Дорнод аймаг дахь Статистикийн хэлтэс	1	1				1		
11	Дундговь аймаг дахь Статистикийн хэлтэс	1	1				1		
12	Завхан аймаг дахь Статистикийн хэлтэс	1	1				1		

13	Орхон аймаг дахь Статистикийн хэлтэс	1	1				1			
14	Өвөрхангай аймаг дахь Статистикийн хэлтэс	1	1				1			
15	Өмнөговь аймаг дахь Статистикийн хэлтэс	1	1				1			
16	Сүхбаатар аймаг дахь Статистикийн хэлтэс	1			1					
17	Сэлэнгэ аймаг дахь Статистикийн хэлтэс	1			1					
18	Төв аймаг дахь Статистикийн хэлтэс	1	1				1			
19	Увс аймаг дахь Статистикийн хэлтэс	1	1				1			
20	Ховд аймаг дахь Статистикийн хэлтэс	1	1				1			
21	Хөвсгөл аймаг дахь Статистикийн хэлтэс	1			1					
22	Хэнтий аймаг дахь Статистикийн хэлтэс	1	1				1			
23	Нийслэл дэх Статистикийн хэлтэс	1	1				1			
24	Үндэсний статистикийн хороо /аппарат/	1		1						
ДҮН		24	20	1	3		20			

Гурав. Аудитын үр дүн

3.1. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/ сая төгрөг/

Д/д	Санхүүгийн тайланд нэгтгэсэн байгууллага, нэгжийн нэр	Алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:						
				Зөвлөмж		Төлбөрийн акт		Албан шаардлага		Хууль хяналтын бусад байгууллагад шилжүүлсэн
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо
А	1	2	3	4	5	6	7	8	9	10
Төсвийн ерөнхийлөн захирагч										
1	Үндэсний статистикийн хорооны дарга	1	-	1	-					
Төсвийн шууд захирагч										
2	Архангай аймаг дахь Статистикийн хэлтэс	2	-	2	-					
3	Булган аймаг дахь Статистикийн хэлтэс	4	0.4	3	-	1	0.4			
4	Говь-Алтай аймаг дахь Статистикийн хэлтэс	9	16.8	1	-	3	2.1	5	14.7	
5	Говьсүмбэр аймаг дахь Статистикийн хэлтэс	5	0.9	3	-	1	0.5	1	0.4	
6	Дархан-Уул аймаг дахь Статистикийн хэлтэс	1	0.2	1	0.2					
7	Дорноговь аймаг дахь Статистикийн хэлтэс	1	2.6	1	2.6					

8	Дорнод аймаг дахь Статистикийн хэлтэс	2	1.1				2	1.1	
9	Дундговь аймаг дахь Статистикийн хэлтэс	1	-				1	-	
10	Орхон аймаг дахь Статистикийн хэлтэс	2	1.4	2	1.4				
11	Өвөрхангай аймаг дахь Статистикийн хэлтэс	1	0.5	1	0.5				
12	Өмнөговь аймаг дахь Статистикийн хэлтэс	4	0.1	2	-	1	0.1	1	-
13	Сүхбаатар аймаг дахь Статистикийн хэлтэс	1	3.3					1	3.3
14	Төв аймаг дахь Статистикийн хэлтэс	3	2.3	3	2.3				
15	Ховд аймаг дахь Статистикийн хэлтэс	2	0.2	2	0.2				
16	Хэнтий аймаг дахь Статистикийн хэлтэс	3	7.8	2	7.3	1	0.5		
17	Нийслэл дэх Статистикийн хэлтэс	6	32.1	4	10.9			2	21.3
18	Үндэсний статистикийн хороо /аппарат/	1	82.9	1	82.9				
Дүн		49	405.8	29	108.1	7	3.7	13	40.8

3.2 . Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг ач холбогдлоор нь эрэмбэлбэл:

Алдаа, зөрчилтэй асуудал 1.

Гэрээт ажилтнуудад хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс илүү нийт 74.1 сая төгрөгийн цалин хөлс, 8.8 сая төгрөгийн хоолны мөнгө нэмж олгосон байна. Энэ нь Хүн ам, орон сууцны тооллогын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-д “ажилгүй болон тэтгэвэрт байгаа хүнийг статистикийн асуудал эрхэлсэн төв байгууллагад тооллогын ажилтнаар ажиллуулсан хугацаанд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцож олгох цалин хөлс олгоно”, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гэрээт ажилтнуудын цалин хөлсийг хууль журамд нийцүүлэн олгох зөвлөмж өгөв.

Алдаа, зөрчилтэй асуудал 2.

Үндэсний статистикийн хорооны харьяа байгууллагуудад хийсэн аудитаар нийт 69.7 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 3.7 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар 40.8 сая төгрөгийн албан шаардлага, 25.2 сая төгрөгийн зөвлөмж хүргүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т "Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 14.2.4-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд тухайн төсөв хэрэгжих жил болон дунд хугацаанд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын арга хэмжээг жилийн төсвийн хязгаарт багтаан санхүүжилтийн бүх төрлийн эх үүсвэртэй нь уялдуулан боловсруулах", 14.2.5-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах", 14.3-т "Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал

эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Харьяа төсвийн шууд захирагчдын санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулах өгөв.



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН
ХОРООНЫ ДАРГА Б.БАТДАВАА
ТАНАА

2021.04.26 № 1324
танай _____ -ны № _____ -т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Үндэсний статистикийн хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Үндэсний статистикийн хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

A square stamp containing a handwritten signature in black ink. The signature is stylized and appears to read 'Д.ЗАНДАНБАТ'.

Д.ЗАНДАНБАТ